

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2014 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үндэсний статистикийн хорооны даргын 2014 оны 03 сарын 27-ны өдрийн А/31 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Үндэсний статистикийн хорооны “2014 оны үйл ажиллагааны тайлан”-д үндэслэн түүнд тусгагдсан үйл ажиллагааны дараах чиглэлүүдэд үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын бүтэц, чиг үүрэг
- Байгууллагын үндсэн үйл ажиллагаа
- Боловсон хүчин, хүний нөөц
- Байгууллагын санхүү, төсвийн үйл ажиллагаа

Хууль зүйн яамнаас 2013 онд боловсруулан аргачлалын дагуу “Баримт бичиг судлах”, “Ажиглалт хийх” аргыг ашиглан системчилсэн үнэлгээг хийсэн болно.

1. Байгууллагын бүтэц, чиг үүрэгт хийсэн үнэлгээний талаар

Үндэсний статистикийн хороо нь 2014 онд Төрийн захиргаа, удирдлагын газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Макро эдийн засгийн статистикийн газар, Хүн ам, нийгмийн статистикийн газар, Мэдээлэл, боловсруулалт, технологийн газар, Эдийн засгийн статистикийн хэлтэс, Хүн орон сууцны тооллогын товчоо, Мэдээлэл сургалт, сурталчилгааны төв зэрэг үндсэн газар, нэгжүүд болон орон нутгийн, нийслэл аймаг, дүүргийн статистикийн газар хэлтсүүдэд нийт 315 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан байна.

2014 онд тус ажлын хэсгээс Үндэсний статистикийн хорооны газар нэгжүүдийн чиг үүрэгт системчилсэн үнэлгээг хийж, тайлан гаргасан ба үнэлгээгээр газар нэгжүүдийн чиг үүргийг боловсронгуй болгох, хүний нөөцийн оновчтой бодлого мөрдөх, сэлгэн ажиллуулах, ажиллагчдын ажлын ачааллыг жигдрүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргасан. Үүний мөрөөр НҮБ-ын статистикийн зөвлөмжид заагдсан үйл ажиллагааны үндсэн 9 үе шатыг баримтлан ҮСХ-ны бүтцийг шинэчлэн сайжруулах, дахин хуваарилах асуудлаар судалгаа гарган хэлэлцүүлж, 2015 оноос эхлэн шинэ бүтэц, чиг үүрэгтэйгээр ажиллаж эхэлсэн. Үүнтэй уялдан ажилтнуудын мэргэжил, мэдлэгийг гүнзгийрүүлэх, орон тоог нэмэгдүүлэх, шинээр нэвтрүүлсэн бүтэц, чиг үүргээр статистикийн үйл ажиллагаа явуулж байгаа бусад улс орнуудын туршлагыг судлах, холбогдох хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

2. Үндсэн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний талаар

Үндэсний статистикийн хороо нь 2014 онд Албан ёсны статистикийг хөгжүүлэх 2011-2015 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө, “Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”, УИХ-ын болон холбогдох Байнгын хорооны хуралдааны тогтоол, тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хүрээнд нийт 130 ажил төлөвлөснөөс Соёл Спорт Аялал Жуулчлалын яамнаас албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн тус яамны захиргааны статистикийн мэдээллийг гаргах аргачлал, асуулга, маягт зааврыг зөвшөөрөх ажилтай холбогдсон 2 асуудлыг салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс хасагджээ. Төлөвлөсөн 128 ажлаас 119 ажлыг бүрэн хийж гүйцэтгэн, 8 ажил нь “хэрэгжиж байгаа” гүйцэтгэлтэй гарч, гүйцэтгэлийн хувь 99.2 байна.

Статистикийн салбарын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн биелүүлэхийн тулд төлөвлөгөөт ажлын биелэлтэд улирал, сар, 7 хоногоор хяналт хийж, биелэлтийг гарган, ҮСХ-ны шуурхай хуралдаанаар дүгнэн, газар, нэгжүүдэд албан ёсоор хүргүүлэн ажилласан байна.

Хийж гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгагдаж хэрэгжиж байгаа ажлууд нь холбогдох газар нэгжүүдийн хэмжээнд гүйцэтгэгдсэн хэдий ч дахин сайжруулан судлах, бусад судалгаа, тооцооны хүрээнд уялдуулан нягтлах, шинэчлэгдэж байгаа боловч эцэслэгдээгүй байгаа олон улсын зөвлөмж, аргачлалыг үндэслэх зэрэг шаардлагаар ҮСХ-ны ДЗХ, АЗБЗ-өөс шийдвэрлэсэн тул хугацаа хойшлогдсон байна.

Нийслэл, аймаг, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнуудын хариуцсан ажлын ачаалалд судалгаа хийж, хүний нөөцийн хэрэгцээг оновчтой тодорхойлох ажлыг хийхээр төлөвлөсөн хэдий ч мэргэжлийн баг гаднаас авч ажиллуулах хөрөнгө, санхүүгийн асуудал шийдэгдээгүйн улмаас биелэгдээгүй.

Сүүлийн жилүүдэд статистикийн мэдээллийг хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээ эрс өсч, тэдгээрийн шаардлагад нийцсэн хүн ам-нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистик мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр өртөг багатайгаар, түргэн, шуурхай хүргэх асуудал статистикийн байгууллагад онцгой тавигдах болсонтой холбогдон шинэ болон шинэлэг үйл ажиллагааг хийж хүргүүлсэн байна.

ҮСХ нь 2014 онд албан ёсны статистикийн сар, улирал, жилийн (давхардсан тоогоор) 236 төрлийн 110.0 мянган мэдээг холбогдох газруудаас хүлээн авч, нэгтгэн, боловсруулж, танилцуулга бэлтгэн, эцсийн бүтээгдэхүүн болгон тархаасан.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн дагуу “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”, “Ажиллах хүчний судалгаа”, “Ардчилсан засаглалын судалгаа”-г хугацаанд нь явуулж, үр дүнг хэрэглэгчид хүргэх ажлыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж, үр дүнг мөн тархаасан байна.

Статистикийн арга зүйг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох ажлын хүрээнд албан ёсны болон захиргааны

статистикийн мэдээллийн үзүүлэлтүүдийг оновчтой болгох чиглэлээр 2014 онд 5 аргачлал, арга зүй шинээр болон шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгожээ.

Салбарын хэмжээнд статистикийн үйл ажиллагаанд техник, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлуудыг хийж, тайлант хугацаанд 17 шинэ программ боловсруулж, 12 программд нэмэлт өөрчлөлт оруулснаас 3 программ нь таблет, 14 программ нь онлайнаар шууд шивэх боломжтой болсон байна.

Статистикийн мэдээллийн сан www.1212.mn сайтыг боловсронгуй болгон ашиглахад хялбар, сангаас авах мэдээллийг нэмэлт програмгүйгээр өөрийн хүссэн хэлбэрээр шууд авах боломжтой болгожээ.

Статистикийн мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой, илүү их эрэлт, хэрэгцээ үүсч буй шаардлагын дагуу хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэх, мэдээллийн санг баяжуулах, веб сайтын ашиглалтыг сайжруулах чиглэлээр болон статистикийн мэдээллийг цахимаар, түүнчилэн инфографик хэлбэрээр тархаахад түлхүү анхаарч ажилласан байна.

Цаашид статистикийн үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсронгуй болгох, хийгдэх ажлын цар хүрээг бодитоор тодорхойлж, үе шаттайгаар ангилан, бусад ажлуудтай уялдуулан (тухайлбал олон улсын зөвлөмж, аргачлал эцэслэн батлагдсаныг нягтлах гэх мэт), шаардлагатай хөрөнгө, зардлыг оновчтой тогтоон төлөвлөх нь зүйтэй гэж үзэж байна.

2014 онд дээр дурдсан гол ажлуудаас гадна төлөвлөгөө, тайланд тусгагдсан олон ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн хэдий ч цаашид статистикийн үйл ажиллагаанд шинэ технологи нэвтрүүлэх ажлыг идэвхитэй үргэлжлүүлэх, мэдээллийн бодит байдлыг хангах, хэрэглэгчдэд хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар хүргэх зэрэгт онцлон анхаарч үүний тулд шат, шатны нэгжид, ялангуяа анхан шатны нэгжид боловсон хүчний боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, компьютер, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, тэдгээрт шаардлагатай санхүү, зардлын асуудлыг шийдүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийж байна.

3. Боловсон хүчин, хүний нөөцөд хийсэн үнэлгээний талаар

Үндэсний статистикийн салбарт 2014 оны жилийн эцсийн байдлаар 315 албан хаагч ажил үүрэг гүйцэтгэж байгаагаас ҮСХ-ны төв аппаратад 111 хүн, орон нутгийн статистикийн газар, хэлтэст 204 хүн ажиллаж байна. Салбарын ажилтнуудын 37.8 хувь нь эрэгтэй, 62.2 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт ажиллагчдын 62.6 хувь нь 10 хүртэл жил ажиллаж байгаа бол 18.9 хувь нь 21-ээс дээш жил төрийн албанд ажиллаж байна. 2014 оны жилийн эцсийн байдлаар статистикийн салбарын ажилтнуудын 36.6 хувь нь эдийн засагч-статистикч, 5.5 хувь нь хүн ам зүйч, 34.8 хувь нь эдийн засагч-нябо, 23.2 хувь нь бусад (инженер, программист) мэргэжилтэй байна. ҮСХ нь ажилтнуудын

боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндэд анхаарах, үүний тулд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, хамруулах, нийгмийн асуудлыг шийдэх зэрэг нилээд ажлуудыг дотоодын боломжид тулгуурлан хийсэн нь сайшаалтай байна. Тухайлбал, төрийн албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгож, тайлант хугацаанд 13 ажилтанд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, нэмэгдүүлэх шийдвэрийг гаргасан байна. Төрийн дээд одон медалаар 34, салбарын шагналаар 18 хүн шагнагдсан байна. Төрийн албан хаагчдын орон сууцны нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд ТОСК /Төрийн орон сууцны корпораци/-д хүсэлт тавьснаар орон сууцны хөнгөлөлттэй зээлийн “Буянт-Ухаа-1” хөтөлбөрт хамрагдах 5 квотыг салбарын ажилтнууддаа авч журмын дагуу шийдвэрлэсэн байна. Ажилтан, албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж, шинээр мэндэлсэн хүүхэд, эмчилгээний зардал зэрэгт давхардсан тоогоор нийт 139 албан хаагчдад 31.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Статистикийн үйл ажиллагааны тайланд тусгагдсан тоо, баримт, ажиглалт зэрэгт үндэслэн боловсон хүчин, хүний нөөцийн талаар дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд, статистикийн байгууллагад 10-20 хүртэлх жил ажиллаж буй ажилтнуудыг эзлэх хувь харьцангуй бага буюу нийт ажилтнуудын дөнгөж 18.0 орчим хувийг эзэлж байгаа нь цаашид хүний нөөцийн бодлогод илүү түлхүү анхаарах, хөтөлбөр боловсруулах, ажилтнуудыг туршлагажуулах, мэргэшүүлэх, боловсролыг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллуулж, залгамж халааг бэлтгэх, нийгмийн асуудлыг тодорхой үе шатаар шийдэхэд үргэлжлүүлэн анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Ажиглалтын аргаар авч үзэхэд, ҮСХ-ны өрөө, тасалгааны хангамж хүрэлцээгүйгээс нэг өрөөнд 5-7 ажилтан сууж байгаа нь ажлын бүтээмж, үр дүн, мэдээллийн аюулгүй байдал, нууцлал, ажилтнуудын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буйг цаашид анхаарч, холбогдох арга хэмжээ авах шаардлагатай нь харагдаж байна.

Түүнчлэн “Статистикийн тухай” хуулийн 5 бүлгийн 17 дугаар зүйлийн 1 дүгээр заалт, ЗГХЭГ-ын даргын 2013 оны 234 тоотын дагуу аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ нь статистикийн хэлтэс, газрыг ажиллах нөхцөл боломжоор хангах, ЗДТГ-ын байранд байрлуулах, байрны ашиглалтын зардлыг орон нутгийн төсөвт тусгах ёстойг байнга анхааруулсаар байтал өрөө, тасалгаа, дулаан, усны зардал, түрээсийн зардал нэхдэг, багтаамж, орчин нөхцөл муутай өрөө, тасалгаа хувиарладаг, байр, сууцаар хангах боломжгүй гэсэн шалтгаанаар хөөдөг явдал байсаар байгааг шийдвэрлэх шаардлагатай байна.

4. Байгууллагын санхүү, төсвийн талаар

Үндэсний статистикийн хорооны системийн хэмжээгээр 2014 оны үйл ажиллагааны урсгал зардалд 9944.4 сая төгрөгний төсөв батлагдснаас 7493.2 сая төгрөгийг зарцуулж, 2.5 тэрбум төгрөгийн хэмнэлтийг гаргажээ.

“Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хүүхэд хөгжил судалгаа”, “Хүн ам зүй, эрүүл мэнд” гэсэн 3 тусдаа явагддаг судалгааг нэгтгэн, “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа” нэртэйгээр нэгдсэн судалгаа болгон хуулийн хүрээнд шийдвэрлэн явуулсан нь дээрх хэмнэлтийг гаргах боломжийг нээжээ.

2013 оны жилийн эцсийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийн тооллогын ажлыг зохион байгуулж, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон 47 нэр төрлийн 196.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл авч зохих журмын дагуу акталж устгасан байна.

Статистикийн салбарын төсөв, санхүүгийн байдал, сүүлийн 3 жилээр, сая төг

| Орлогын төрөл | 2012 | 2013 | 2014 |
|-------------------|--------|--------|--------|
| Урсгал санхүүжилт | 3712.6 | 7148.5 | 7493.2 |
| Хөрөнгө оруулалт | 424.8 | 231.0 | - |

2013 оны Хорооны санхүүгийн багцын тайлан балансыг нэгтгэн гаргаж Үндэсний аудитын хороо болон Сангийн яамны Төрийн санд хуулийн хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд аудитын дүгнэлтээр “Зөрчилгүй” санал дүгнэлттэй гарсан байна.

Урсгал зардлыг төсвийн тодотголоор танаж хасдаг, хөрөнгө оруулалтын зардлыг бага хэмжээгээр олгодог, зарим тохиолдолд, тухайлбал 2014 онд огт олгоогүй зэрэг шалтгааны улмаас статистикийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмж элэгдэж муудах, ашиглалтгүй болох, анхан шатны нэгжид техник тоног, төхөөрөмж хүрэлцэхгүй болсноос сөрөг үр дагаврууд гарсан байна. Мөн ҮСХ нь жил бүр төсвийн хэмнэлт гаргаж байгаа хэдий ч хэмнэлтэд олгох урамшуулалыг бүрэн олгоогүй байна.

Санхүү, төсвийн талаарх энэ асуудлуудыг холбогдох байгууллагууд шийдэхгүй байгааг энд онцлон тэмдэглэж байна.

5. Статистикийн салбарын 2014 оны үйл ажиллагаанд гарсан ахиц, дэвшил

- **Мэдээллийн технологийг статистикийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг шинэ шатанд гаргасан байна.**

Төрийн байгууллагуудад бий болсон мэдээллийн санг судалж, ашиглах, уялдуулах ажлыг эхлүүлж, Үндэсний дата төвд байрлах УБЕГ-ын иргэний мэдээллийн санг Хүн ам, өрхийн мэдээллийн сантай; хуулийн этгээдийн мэдээллийн санг Бизнес регистрийн мэдээллийн сантай уялдуулах ажлуудыг амжилттай гүйцэтгэж, статистикийн үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн байна.

Мал тооллогын онлайн системийг нэвтрүүлж, багийн түвшинд мал тооллогын дүнг мэдээллийн санд шууд ачааллах, үр дүнгийн 40 төрлийн тайланг улс, аймаг, сум, багийн түвшинд богино хугацаанд шуурхай нэгтгэх, малын тоог өрхийн түвшинд эрэмблэн гаргах зэрэг өргөн боломжуудыг бүрдүүлж чаджээ.

Технологийн шийдлийг ашиглан малчдад банкны үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх үүднээс мал тооллогын дүнг банкны үйл ажиллагаанд ашиглах онлайн системийг нэвтрүүлж, Монгол Банк, Үйлдвэрлэл Хөдөө Аж Ахуйн яамтай хамтран зээл авахаар хүсэлт гаргасан мал бүхий иргэний албан ёсны зөвшөөрөлд үндэслэн тооллогын мэдээллийн сангаас холбогдох лавлагааг авах үйлчилгээг 43 мянган иргэнд үзүүлжээ.

Мэдээллийн технологийн сүүлийн үеийн ололтуудыг ашигласны дүнд ихээхэн хэмжээний цаг хугацаа, зардал хэмнэв. Go-To-Meeting программыг ашиглан салбарын хэмжээний болон дэлхийн улс орнуудын хооронд видео хурал, онлайн сургалтыг зохион байгуулдаг боллоо. НҮТС, ӨНЭЗС, АХС зэрэг судалгааны мэдээллийг цуглуулахад таблет ашиглаж, ажиллагсдын дундаж цалинг НДЕГ-ын мэдээллийн санд үндэслэн тооцдог болсон нь цаг хугацаа, хөрөнгө, хүч хэмнэсэн чухал арга хэмжээ болсон байна.

- **Тооллого, судалгааны ажилд шинэ дэвшлийг гаргасан байна.**

Олон улсад нийтлэг мөрддөг аргачлал, арга зүй, дэлхийн улс орнууд болон өөрийн орны өмнө нь хэрэгжүүлсэн туршлагад үндэслэн Монгол улсын **ГУРВАН САЯ** дахь иргэнийг тусгай хөтөлбөр, арга зүйн дагуу тодруулжээ.

“ҮТС-2008” зөвлөмжийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 5 жил тутам байгуулдаг макро түвшний нэгдсэн тэнцэл болох “Нөөц, ашиглалтын хүснэгт”-ийг 2010-2013 онуудаар, түүнчлэн Үндэсний тооцооны дансны бүрэлдэхүүн хэсэг болох санхүүгийн данс болон хөрөнгийн биет өөрчлөлтийн дансыг туршилтын журмаар анх удаагаа байгуулсан байна.

Байгаль орчин, ногоон өсөлтийг тодорхойлох үзүүлэлтийн системийг тодорхойлж, байгаль орчны анхдагч, суурь данс болох Материал урсгалын дансыг анх удаагаа байгуулсан байна.

Тогтмол хийгддэг судалгаа-ӨНЭЗС, Ардчилсан засаглал судалгаа, Ажиллах хүчний судалгаанаас гадна өрхийн цаг уурын хүндрэлийг даван туулж буй байдлын панел судалгаа, гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн байдалд хийсэн баримтын судалгаа зэргийг гүйцэтгэн дүнг хэрэглэгчдэд тархаажээ.

- **Аргачлал, ангилал, стандартыг нэвтрүүлж, нэгдсэн болон орон нутгийн статистикийн үзүүлэлтийн хүрээг шинэчлэсэн байна.**

“Хүний хөгжлийн индекс”-ийг тооцох болон “Хөдөлмөрийн маргаантай холбоотой статистикийн үзүүлэлт” тооцох аргачлалыг шинээр боловсруулан, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох”, “Хэрэглээний үнийн индекс тооцох” аргачлалд нэмэлт өөрчлөлтийг тусгажээ. Боловсролын түвшний стандарт ангилал, Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийн ангиллыг батлуулж мөрдүүлсэн байна.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулинд заасан 48 бүлэг үзүүлэлтэд үнэлгээг хийж, 82 нэгдсэн үзүүлэлт, 346 дэд үзүүлэлтүүд байхаар нарийвчлан задалж, тэдгээрээс аймаг, нийслэлийн түвшинд гарах 216 үзүүлэлт, сум, дүүргийн түвшинд 148, баг, хорооны түвшинд 35 үзүүлэлтийг тодорхойлж, хүн ам-нийгэм, эдийн засгийн үндсэн 2 бүлэг бүхий 16 дэд салбарын үзүүлэлтийг багтаасан, баг, сум, аймгийн түвшний мэдээллийг агуулсан “Статистикийн товчоон” бүтээлийг аймаг, нийслэлээр боловсруулж, нийтийн хүртээл болгожээ.

- **Статистикийн боловсрол, хэрэглээний үр өгөөжийг дээшлүүлснээр мэдээллийн үйлчилгээнд онлайн хэлбэр давамгайлдаг болсон байна.**

Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас хэрэглэгч мэдээллээ авахдаа өөрийн хүссэн хэлбэрээр шууд авах техникийн шийдлийг бүрдүүлж, статистикийн мэдээллийг инфографикаар болон цахим хэлбэрээр хүргэхэд түлхүү анхаарч ажилласан байна.

Статистикийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээг авч хэрэгжүүлсний дотор аймгуудын ЗДТГ-ын, бизнес, аж ахуйн нэгжийн, хэвлэл, мэдээллийг байгууллагын ажилтнуудад болон их, дээд, сургуулийн оюутнуудад статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Monstat, Ezstat зэрэг апплейкешнээс мэдээллийг авах, ашиглах талаар болон статистикийн мэдээллийг татах, боловсруулах, ашиглах талаар зорилтот сургалтууд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан тусгай сургалт явуулсан нь ихээхэн ач холбогдолтой болсон байна.

- **Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа биеллээ олсон байна.**

ХБНАБалба улсын Статистикийн төв товчоо болон Казахстан улсын Статистикийн газрын төлөөлөгчид ҮСХ-ны үйл ажиллагаатай танилцаж, статистикийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл явц болон, хөдөө аж ахуйн статистикийн үйл ажиллагааны талаар туршлага судалсан нь Монгол Улсын статистикийн байгууллагын үйл ажиллагаа олон улсын түвшинд хүрч, үнэлэгдэж байгаагийн илрэл болсон байна.

Монгол Улсын үндэсний статистикийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжсэн “Монстат төсөл”-ийн хаалтын хурлыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулж, хуралд төслийг хамтран хэрэгжүүлэгч Консорциум /Дестатис, Костат/, Дэлхийн Банк, МУ-ын яамд, агентлагууд, хэрэглэгчид оролцжээ.

НҮБ-ын Статистикийн комиссын 45-р чуулганд оролцох үедээ тусгайлсан уулзалтуудыг зохион байгуулсны нэг нь Монгол Улс, Австралийн хамтран санаачилсан “Нөөцөд суурилсан эдийн засагтай улс орнуудын статистикийн асуудлаарх Улаанбаатар хотын бүлэг”-ийн Удирдах зөвлөлийн өргөтгөсөн уулзалт болж уулзалтаар тус бүлгээс 2013 онд хэрэгжүүлсэн ажил, 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, НҮБАҮХБ-ын дэмжлэгтэйгээр Австрийн Вена хотноо зохион байгуулах Удирдах хорооны 3 дугаар хурлын хөтөлбөрийн төсөл, УБХБ-ийн үйл ажиллагаанд мэдээлэл харилцааны шинэ техник, технологийг өргөнөөр ашиглах талаар хэлэлцсэн байна.

- **Статистикийн салбарын үнэлгээ гадаад болон дотоод талдаа аль алинд нь өндөр байжээ.**

Монгол Улсын үндэсний статистикийн системд НҮБЕЭЗК-ын Статистикийн хэлтэс, НҮБ-ын АНДЭЗНК, Европын Чөлөөт Худалдааны Ассоциаци, Норвегийн Статистикийн газрын төлөөлөгчдөөс бүрдсэн олон улсын үнэлгээний баг анх удаа цогц үнэлгээ хийж энэхүү үнэлгээний үр дүн нь статистикийн салбарын хүрсэн түвшнээ бусадтай харьцуулах боломжийг олж харахад, өөрсдийн давуу болон сул талаа илүү мэдрэхэд, давуу талаа түшиглэн сул талаа засах боломжийг олоход, үйл ажиллагаагаа цаашид сайжруулах гарцыг нээхэд онцгой ач холбогдолтой болжээ. Уг үнэлгээний дүнд суурилан “Үндэсний статистикийн системийн хөгжилд олон улсын цогц үнэлгээний гүйцэтгэх үүрэг” сэдэвт олон улсын дээд хэмжээний уулзалт семинар зохион байгуулж, шинжээчдийн багийн дүгнэлтийг хамтран ажилладаг гадаадын 20 гаруй орны түншүүд болон дотоодын хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран хэлэлцсэн бөгөөд үндэсний статистикийн салбарын ажлын ололт амжилтыг олон улсын баг болон статистикийн байгууллагын төлөөлөл өндөрөөр үнэлэсэн байна.

Цогц үнэлгээний дүнгээр: МУ-ын статистикийн тухай хууль болон түүнийг зохицуулах арга механизм нь тогтворжсоныг; статистикийн үйл ажиллагаа нь идэвхтэй хөгжиж, улс орныхоо бусад салбарын хувьд тэргүүлэх байр суурийг эзэлж байгааг, ҮСХ нь ОУ-ын байгууллагуудаас гаргасан статистикийн стандарт болон шилдэг туршлагыг өөрийн үйл ажиллагаа болон хамтрагч байгууллага/яам, агентлаг, ААНБ/-ууддаа оновчтой нэвтрүүлж байгааг, олон талт болон хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлснээр Монстат зэрэг хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлж салбарын чадавхийг бэхжүүлснийг онцлон тэмдэглэсэн байна.

Монстат төслийн хүрээнд статистикийн мэдээллийг хэрэглэгчдийн дунд явуулсан хөндлөнгийн судалгааны дүнгээр хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин хоёр жилийн өмнөхөөс арван баллын үнэлгээгээр 6.68-аас 7.10 болж нэмэгджээ.

Монгол Улсын үндэсний статистикийн чадавхи, үйл ажиллагаа эрс өсч ирснийг олон улсын бие даасан байгууллагуудын мэдээллийн эх үүсвэрүүд харуулж, Дэлхийн банкны улс орнуудын статистикийн байгууллагын чадавхийн жил бүрийн үнэлгээгээр 2013 онд Монгол Улсын Үндэсний статистикийн чадавхийн ерөнхий дундаж оноо 83 болж, Дэлхийн дунджаас 15 нэгжээр дээгүүр байгаа бөгөөд статистикийн аргачлалаар 70, мэдээллийн эх үүсвэрээр 100 баллын үнэлгээг тус тус авсан байна.

Дүгнэлт гаргасан:

ҮСХ-ны үнэлгээний ажлын хэсэг

2015 оны 4 сар